

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Цагдаагийн газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2025/090/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn www.open.audit.mn Сүхбаатар сум 2025 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: enkhuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Аудитор: О.Анхбаяр Утас: 7036-2442 Цахим хаяг: ankhbayaro@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. АУДИТЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	12
4. АУДИТЫН ТАЙЛАН	17
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
4.5.1 Завсрын аудитын талаар	19
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	20
5.1 Төлбөрийн акт	20
5.2 Албан шаардлага	20
5.3 Зөвлөмж	20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	22

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ГХУС	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай
УИХ	Улсын их хурал
ХЗДХЯ	Хууль зүй дотоод хэргийн яам
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЦАГДААГИЙН
ГАЗРЫН ДАРГА С.БАТХУЯГ ТАНАА

2023.02.14 № САА-2023/090/НА-СТА-ТМЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Цагдаагийн газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Цагдаагийн газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Нэмэлт санхүүжилтийн дансанд 2023 оны гүйцэтгэлээр 129,519.8 мянган төгрөгийн орлого төвлөрч байсан бол тайлант оны гүйцэтгэлээр 349,767.2 мянган төгрөг болж 2.7 дахин нэмэгдсэн байна.

Аудитын гол асуудал

Тус газар нь ЦЕГ-ын даргын 2013 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн 422 дугаар тушаалаар баталсан ЦЕГ болон түүний харьяа байгууллагуудын хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байгаа нь тухайн цаг үеэс хойш нягтлан бодох бүртгэлтэй холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам зэрэг хууль эрх зүйн актуудад орсон өөрчлөлтүүд мөрдөгдөхгүй байх эрсдэлийг үүсгэж байна.

4325020213

Бусад асуудлын хэсэг

Сэлэнгэ аймгийн Цагдаагийн газар нь тайлант онд “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-нд 25 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 91.5 хувиар дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	367,797,021.63	441,220,818.91
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	86,634,027.50	68,257,523.78
31200	Банканд байгаа бэлэн мөнгө	86,634,027.50	68,257,523.78
31210	Төгрөг	86,634,027.50	68,257,523.78
31211	Төрийн сангийн харилцах	86,634,027.50	68,257,523.78
33	АВЛАГА	17,602,000.00	25,533,000.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	17,602,000.00	25,533,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	263,560,994.13	347,430,295.13
35100	Түүхий эд материал	114,751,818.01	171,248,341.51
35110	Тусгай зориулалттай материал	107,659,818.01	164,608,573.51
35130	Эм боох материал	7,092,000.00	6,639,768.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	0.00	14,934,000.00
35400	Хангамжийн материал	141,387,776.12	147,051,073.62
35410	Бичиг хэргийн материал	3,545,210.00	5,195,952.50
35420	Аж ахуйн материал	81,621,768.02	84,139,713.02
35440	Түлш, шатах тослох материал	51,208,631.60	30,007,961.60
35450	Барилгын засварын материал	0.00	7,931,000.00
35460	Хүнсний материал	7.50	7.50
35470	Бусад хангамжийн материал	5,012,159.00	19,776,439.00
35600	Мал амьтад	7,421,400.00	14,196,880.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,609,337,727.50	2,247,450,204.51
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,609,337,727.50	2,247,450,204.51
39200	Биет хөрөнгө	1,365,685,127.62	2,016,281,771.35
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,359,309,136.30	1,359,309,136.30
39202	Хуримтлагдсан элэгдэл	-347,494,525.66	-422,954,320.46
39203	Авто-тээврийн хэрэгсэл	239,155,766.00	563,442,766.19
39204	Хуримтлагдсан элэгдэл	-172,808,999.62	-178,272,561.49
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	684,001,758.89	1,163,164,528.89
39206	Хуримтлагдсан элэгдэл	-486,703,412.66	-562,967,461.88
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	93,977,677.23	107,902,677.23
39208	Хуримтлагдсан элэгдэл	-64,764,072.98	-74,329,793.43
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	60,986,800.00	60,986,800.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	6,093,800.00	6,093,800.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-6,068,799.88	-6,093,800.00
39300	Биет бус хөрөнгө	243,652,599.88	231,168,433.16
39301	Программ хангамж	56,298,180.80	64,558,180.80
39302	Хуримтлагдсан элэгдэл	-36,104,680.92	-56,848,847.64
39303	Бусад биет бус хөрөнгө	223,459,100.00	223,459,100.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,977,134,749.13	2,688,671,023.42
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	7,931,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	7,931,000.00
41300	Өглөг	0.00	7,931,000.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	0.00	7,931,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,977,134,749.13	2,680,740,023.42
51	Засгийн газрын хувь оролцоо	1,977,134,749.13	2,680,740,023.42
51100	Засгийн газрын оруулсан капитал	1,226,962,655.49	1,226,962,655.49
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	1,226,962,655.49	1,226,962,655.49
51200	Хуримтлагдсан үр дүн	-94,814,513.10	608,790,761.19

51210	Өмнөх үеийн үр дүн	-93,350,274.60	-94,814,513.10
51220	Тайлант үеийн үр дүн	-1,464,238.50	703,605,274.29
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	844,986,606.74	844,986,606.74
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,977,134,749.13	2,688,671,023.42

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,553,527,207.82	6,657,833,209.69
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	118,573,857.82	879,149,505.69
120	Нийтлэг татварын бус орлого	118,573,857.82	879,149,505.69
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	45,756,985.00	13,562,830.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	11,964,200.00	13,562,830.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	33,792,785.00	0.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	19,205,000.00	771,181,253.19
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	53,611,872.82	94,405,422.50
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,434,953,350.00	5,778,683,704.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	4,323,035,500.00	5,446,518,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,323,035,500.00	5,446,518,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	111,917,850.00	332,165,204.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	53,721,400.00	224,197,004.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	590,000.00	96,478,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	57,606,450.00	11,490,200.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	4,553,685,237.91	5,949,217,030.71
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,553,685,237.91	5,949,217,030.71
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,090,499,062.01	5,425,756,488.71
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,403,434,205.79	4,429,082,352.09
210101	Үндсэн цалин	2,234,467,943.12	2,248,958,893.21
210102	Нэмэгдэл	1,115,439,382.76	1,585,132,472.78
210103	Унаа хоолны хөнгөлөлт	26,449,020.00	65,348,935.86
210104	Урамшуулал	27,077,859.91	529,642,050.24
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	78,950,024.31	91,885,051.63
210201	Тэтгэврийн даатгал	427,549.00	2,827,393.00
210202	Тэтгэмжийн даатгал	58,042.00	332,634.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	39,650.00	266,108.00
210204	Ажилгүйдлийн даатгал	7,883.00	66,527.00
210205	Эрүүл мэндийн даатгал	78,416,900.31	88,392,389.63
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	83,845,551.91	145,134,930.00
210301	Гэрэл, цахилгаан	13,503,445.91	24,709,600.00
210302	Түлш, халаалт	61,076,816.00	96,480,000.00
210303	Цэвэр, бохир ус	9,265,290.00	23,945,330.00
2104	Хангамж, бараа материалын зардал	204,978,341.97	297,807,463.00
210401	Бичиг хэрэг	15,673,730.00	22,393,020.00
210402	Тээвэр, шатахуун	133,175,861.00	182,226,970.00

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	11,827,232.09	39,389,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	9,470,000.00	400,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,797,800.00	44,153,160.00
210408	Бараа материал акталсны зардал	27,033,718.88	9,245,113.00
2105	Нормативт зардал	20,354,397.50	89,144,132.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	0.00	752,232.00
210502	Хоол, хүнс	19,969,797.50	88,391,900.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	384,600.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	32,790,083.00	41,700,575.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	265,000.00	0.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	414,000.00	0.00
210604	Урсгал засвар	32,111,083.00	41,700,575.00
2107	Томилолт, зочны зардал	9,582,800.00	37,133,000.00
210702	Дотоод албан томилолт	9,582,800.00	37,133,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,915,720.00	31,669,370.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,389,500.00	31,222,766.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	0.00	78,484.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	0.00	48,900.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,000,000.00	0.00
210807	Газрын төлбөр	151,780.00	0.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	374,440.00	319,220.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	246,647,937.53	262,199,614.99
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	500,000.00	450,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,040,462.00	7,924,226.50
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	245,107,475.53	253,825,388.49
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	463,186,175.90	523,460,542.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	451,110,134.00	520,101,200.20
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	7,175,980.00	6,325,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	232,503,454.00	348,128,796.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	112,311,200.00	75,378,904.20
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	99,119,500.00	90,268,500.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	12,076,041.90	3,359,341.80
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,470,051.90	1,928,325.00
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	3,605,990.00	1,431,016.80
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-158,030.09	708,616,178.98
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	26,706,400.96	0.00
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	26,706,400.96	0.00
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	28,012,609.37	5,010,904.69
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	27,912,609.37	4,536,904.69
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	100,000.00	474,000.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-1,464,238.50	703,605,274.29

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	4,537,741,445.00	5,825,715,030.28
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	85,186,095.00	28,439,326.28
120	Нийтлэг татварын бус орлого	85,186,095.00	28,439,326.28
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	85,186,095.00	28,439,326.28
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	11,964,200.00	13,562,830.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	73,221,895.00	14,876,496.28
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,452,555,350.00	5,797,275,704.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	4,323,035,500.00	5,446,518,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,323,035,500.00	5,446,518,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	129,519,850.00	350,757,204.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	53,721,400.00	225,187,004.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	590,000.00	96,478,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	75,208,450.00	29,092,200.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,411,087,882.50	5,718,798,017.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,411,087,882.50	5,718,798,017.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,925,951,706.60	5,168,304,475.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,449,963,394.07	4,433,109,900.00
210101	Үндсэн цалин	2,112,261,142.66	2,249,642,886.16
210102	Нэмэгдэл	1,233,244,005.50	1,588,476,027.74
210103	Унаа хоолны хөнгөлөлт	33,770,660.00	65,348,935.86
210104	Урамшуулал	70,687,585.91	529,642,050.24
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	72,409,336.03	94,634,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	72,409,336.03	94,634,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	84,745,551.91	145,134,930.00
210301	Гэрэл, цахилгаан	14,103,445.91	24,709,600.00
210302	Түлш, халаалт	61,376,816.00	96,480,000.00
210303	Цэвэр, бохир ус	9,265,290.00	23,945,330.00
2104	Хангамж, бараа материалын зардал	206,128,732.09	226,971,720.00
210401	Бичиг хэрэг	12,445,100.00	21,041,620.00
210402	Тээвэр, шатахуун	177,096,000.00	161,159,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	11,827,232.09	39,389,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	300,000.00	400,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,460,400.00	4,981,100.00
2105	Нормативт зардал	27,506,197.50	103,570,900.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	180,000.00	945,000.00
210502	Хоол, хүнс	25,826,197.50	87,241,900.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,500,000.00	15,384,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	34,923,495.00	66,703,675.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,855,695.00	21,323,800.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,000,000.00	3,890,000.00
210604	Урсгал засвар	28,067,800.00	41,489,875.00
2107	Томилолт, зочны зардал	11,691,900.00	37,133,000.00
210702	Дотоод албан томилолт	11,691,900.00	37,133,000.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	23,728,500.00	49,464,150.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	18,600,000.00	46,866,766.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	446,500.00	78,484.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	232,000.00	48,900.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,000,000.00	2,470,000.00
210807	Газрын төлбөр	450,000.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,854,600.00	11,582,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,390,000.00	0.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,464,600.00	11,582,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	485,136,175.90	550,493,542.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	455,458,134.00	521,601,200.20
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	14,495,980.00	7,825,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	232,503,454.00	348,128,796.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	112,311,200.00	75,378,904.20
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	96,147,500.00	90,268,500.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	29,678,041.90	28,892,341.80
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,470,051.90	1,431,016.80
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	21,207,990.00	27,461,325.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	126,653,562.50	106,917,013.28
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	68,662,335.00	125,293,517.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	68,662,335.00	125,293,517.00
2200	Дотоод эх үүсвэрээр	68,662,335.00	125,293,517.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	68,662,335.00	125,293,517.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-68,662,335.00	-125,293,517.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	57,991,227.50	-18,376,503.72
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	28,642,800.00	86,634,027.50
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	86,634,027.50	68,257,523.78

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,226,962,655.49	844,986,606.74	-93,350,274.60	1,978,598,987.63
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,226,962,655.49	844,986,606.74	-93,350,274.60	1,978,598,987.63
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-1,464,238.50	-1,464,238.50
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,226,962,655.49	844,986,606.74	-94,814,513.10	1,977,134,749.13

11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,226,962,655.49	844,986,606.74	-94,814,513.10	1,977,134,749.13
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,226,962,655.49	844,986,606.74	-94,814,513.10	1,977,134,749.13
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	703,605,274.29	703,605,274.29
20	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,226,962,655.49	844,986,606.74	608,790,761.19	2,680,740,023.42

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү /хэтрэлт, хэмнэлт/	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,459,518,500.00	5,458,650,313.20	-868,186.80	99.98
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,459,518,500.00	5,458,650,313.20	-868,186.80	99.98
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,971,030,500.00	4,970,302,113.00	-728,387.00	99.99
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,433,109,900.00	4,433,109,900.00	0.00	100.00
210101	Үндсэн цалин	2,263,971,500.00	2,249,642,886.16	-14,328,613.84	99.37
210102	Нэмэгдэл	1,604,898,400.00	1,588,476,027.74	-16,422,372.26	98.98
210103	Унаа хоолны хөнгөлөлт	44,240,000.00	65,348,935.86	21,108,935.86	147.71
210104	Урамшуулал	520,000,000.00	529,642,050.24	9,642,050.24	101.85
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	94,634,000.00	94,634,000.00	0.00	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	94,634,000.00	94,634,000.00	0.00	100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	145,135,100.00	145,134,930.00	-170.00	100.00
210301	Гэрэл, цахилгаан	24,709,600.00	24,709,600.00	0.00	100.00
210302	Түлш, халаалт	96,480,000.00	96,480,000.00	0.00	100.00
210303	Цэвэр, бохир ус	23,945,500.00	23,945,330.00	-170.00	100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	187,514,000.00	187,506,720.00	-7,280.00	100.00
210401	Бичиг хэрэг	21,045,000.00	21,041,620.00	-3,380.00	99.98
210402	Тээвэр, шатахуун	148,324,800.00	148,324,800.00	0.00	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	12,759,200.00	12,759,200.00	0.00	100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	400,000.00	400,000.00	0.00	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,985,000.00	4,981,100.00	-3,900.00	99.92
2105	Нормативт зардал	15,149,000.00	15,129,900.00	-19,100.00	99.87
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	300,000.00	300,000.00	0.00	100.00
210502	Хоол, хүнс	13,349,000.00	13,329,900.00	-19,100.00	99.86
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,500,000.00	1,500,000.00	0.00	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	42,161,000.00	41,970,493.00	-190,507.00	99.55
210601	Багаж, техник, хэрэгсэл	12,000,000.00	11,560,142.00	-439,858.00	96.33
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,000,000.00	2,000,000.00	0.00	100.00

210604	Урсгал засвар	28,161,000.00	28,410,351.00	249,351.00	100.89
2107	Томилолт, зочны зардал	28,623,000.00	28,623,000.00	0.00	100.00
210702	Дотоод албан томилолт	28,623,000.00	28,623,000.00	0.00	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	22,204,500.00	21,693,170.00	-511,330.00	97.70
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	19,100,000.00	19,095,786.00	-4,214.00	99.98
210804	Тээврийн хэрэгслийн татвар	446,500.00	78,484.00	-368,016.00	17.58
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	188,000.00	48,900.00	-139,100.00	26.01
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,470,000.00	2,470,000.00	0.00	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,500,000.00	2,500,000.00	0.00	100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,500,000.00	2,500,000.00	0.00	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	488,488,000.00	488,348,200.20	-139,799.80	99.97
2132	Бусад урсгал шилжүүлэг	488,488,000.00	488,348,200.20	-139,799.80	99.97
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,500,000.00	1,500,000.00	0.00	100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	348,129,000.00	348,128,796.00	-204.00	100.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	75,379,000.00	75,378,904.20	-95.80	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	63,480,000.00	63,340,500.00	-139,500.00	99.78
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	5,459,518,500.00	5,458,650,313.20	-868,186.80	99.98
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	5,446,518,500.00	5,445,087,483.20	-1,431,016.80	99.97
310001	Улсын төсвөөс санхүүжих	5,446,518,500.00	5,445,087,483.20	-1,431,016.80	99.97
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	13,000,000.00	13,562,830.00	562,830.00	104.33
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	13,000,000.00	13,562,830.00	562,830.00	104.33

2.5 Нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	350,757,204.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	350,757,204.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	323,295,879.00
2104	Хангамж, бараа материалын зардал	39,465,000.00
210402	Тээвэр, шатахуун	12,835,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	26,630,000.00
2105	Нормативт зардал	88,441,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	645,000.00
210502	Хоол, хүнс	73,912,000.00

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	13,884,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	109,576,699.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	94,607,175.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,890,000.00
210604	Урсгал засвар	13,079,524.00
2107	Томилолт, зочны зардал	8,510,000.00
210702	Дотоод албан томилолт	8,510,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	68,220,980.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	68,220,980.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,082,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,082,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	27,461,325.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	27,461,325.00
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	27,461,325.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	350,757,204.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	350,757,204.00
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	225,187,004.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	96,478,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	29,092,200.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Цагдаагийн газар /цаашид Аймгийн Цагдаагийн газар гэх/ нь “Найдвартай, баталгаатай үйлчилгээ-иргэд олон нийтийн итгэл, дэмжлэгийг нэмэгдүүлэх” гэсэн зорилтын хүрээнд үйл ажиллагаа явуулсан байна.

Байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлж, хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

- Гэмт хэрэгтэй тэмцэх,
- Нийгмийн хэв журам сахиулах,
- Олон нийтийн аюулгүй байдлыг хангах,
- Захиргааны хяналт тавих үүрэг гүйцэтгэх буюу хуулиар хүлээлгэсэн хуулийн биелэлтэд хяналт тавих.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Хөдөлмөрийн тухай хуульд 2024 оны 01 дугаар сарын 12, 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн хэмнэлт тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 17, 12 дугаар сарын 12-нд нэмэлт өөрчлөлт орсон,

- Цагдаагийн албаны тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 12, 06 дугаар сарын 05, 10 дугаар сарын 18-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн албаны тухай хуульд 2024 оны 05 дугаар сарын 16, 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ний өдрийн 128 дугаар тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Тайлант онд аймгийн Цагдаагийн газрын санхүүгийн үйл ажиллагаанд сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан тухай бүр хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Аймгийн Цагдаагийн газрын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг **аккруэл** сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

ЦЕГ-ын даргын 2013 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн 422 дугаар тушаалаар ЦЕГ болон түүний харьяа байгууллагуудын хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталсан байна.

Уг баримт бичгийг баталсан 2013 оноос хойш нягтлан бодох бүртгэлтэй холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам зэрэг хууль эрх зүйн актуудад ихээхэн хэмжээний өөрчлөлт орсон байна. Иймд Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэсэн заалтын дагуу нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллах нь зүйтэй юм.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Аймгийн Цагдаагийн газрын 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/З дугаар тушаалаар баталсан Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 711,536.3 мянган төгрөгөөр буюу 35.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	86,634.0	68,257.5	-18,376.5
Авлага	17,602.0	25,533.0	7,931.0
Бараа материал	263,561.0	347,430.3	83,869.3
Үндсэн хөрөнгө	1,609,337.7	2,247,450.2	638,112.5
Нийт хөрөнгө	1,977,134.7	2,688,671.0	711,536.3
Өр төлбөр	0.0	7,931.0	7,931.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,977,134.7	2,680,740.0	703,605.3
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,977,134.7	2,688,671.0	711,536.3

Дээрх хүснэгтээс харахад нөлөө бүхий өөрчлөлт гарсан дараах данснууд байна. Үүнд:

Бараа материалын дансны үлдэгдэл 347,430.3 мянган төгрөг болж 83,869.3 мянган төгрөгөөр өссөн нь дараах хүчин зүйлүүдээс шалтгаалсан байна. Үүнд:

- Төсвийн хөрөнгөөр 306,314.9 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан,
- 79,508.1 мянган төгрөгийн бараа материал үнэ төлбөргүй хүлээн авсан,
- Үйл ажиллагаанд 298,893.5 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан гэх мэт.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,247,450.2 мянган төгрөг болж 638,112.5 мянган төгрөгөөр өссөн нь аймгийн ЗДТГ, ХЗДХЯ, ЦЕГ зэрэг байгууллагуудаас 771,181.3 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авсан болон 57,900.0 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, устгасан зэргээс голлон шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг тус бүр улсын төсвөөс **5,782,108.0** мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналыг 1,284,974.3 мянган төгрөгөөр бууруулж, нийт **4,541,373.7** мянган төгрөгөөр баталсан байна. Үүнд:

- *Томилолт, зочны зардлыг 63,00.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж,*

- Цалин хөлс болон нэмэгдэл урамшил зардлыг 180,879.0 мянган төгрөгөөр,
- Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 16,386.1 мянган төгрөгөөр,
- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 120,451.9 мянган төгрөгөөр,
- Хангамж бараа материалын зардлыг 113,445.6 мянган төгрөгөөр,
- Нормативт зардлыг 16,514.5 мянган төгрөгөөр,
- Эд хогшил, урсгал засварын зардлыг 244,806.0 мянган төгрөгөөр,
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 14,158.5 мянган төгрөгөөр,
- Бараа үйлчилгээний бусад зардлыг 3,645.0 мянган төгрөгөөр,
- Бусад урсгал шилжүүлгийн зардлыг 574,750.7 мянган төгрөгөөр зэрэг.

Төсвийн жилийн дундуур батлагдсан төсвийг 918,144.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн /цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 362,795.3 мянган төгрөгөөр, урсгал шилжүүлгийн зардлыг 482,182.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн нь голлон нөлөөлсөн байна/ нийт **5,459,518.5** мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна. Үүнд:

- Улсын төсвөөс 5,446,518.5 мянган төгрөг,
- Үндсэн үйл ажиллагааны орлогоос 13,000.0 мянган төгрөг гэх мэт.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн гүйцэтгэлээр төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 5,446,518.5 мянган төгрөгийг улсын төсвөөс, 13,000.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр төлөвлөн гүйцэтгэлээр улсын төсвөөс 5,446,518.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагааны орлогоор 13,562.8 мянган төгрөг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 5,458,650.3 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 728.4 мянган төгрөгөөр хэмнэснээс голлон шалтгаалсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	4,964,430.5	4,963,702.1	728.4	99.9
2	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	488,488.0	488,348.2	139.8	99.9
3	Байцаан шийтгэх ажиллагаа	6,600.0	6,600.0	0.0	100.0
	Дүн	5,459,518.5	5,458,650.3	868.2	99.9

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус газар нь нэмэлт санхүүжилтийн дансанд нийт 349,767.2 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, 322,305.9 мянган төгрөгийг зарцуулан, жилийн эцэст 27,461.3 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна. Нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрсөн орлогын задаргааг харуулбал:

- Өмнөх оны эцэст төвлөрүүлсэн татаас санхүүжилтийн авлага **17,602.0** мянган төгрөг /2022 онд Ерөө сумын ЗДТГ-аас хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хамгаалалтын постын зардалд олгосон 70,000.0 мянган төгрөгийн зарцуулагдаагүй үлдэгдэл/,
- ЦЕГ-аас УИХ-ын ээлжит сонгуулийн хамгаалалтын зардалд 42,328.0 мянган төгрөг, орон нутгийн ИТХ-ын сонгуулийн хамгаалалтын зардалд 54,150.0 мянган төгрөг нийт **96,478.0** мянган төгрөг,
- Аймгийн ИТХ-ын ажлын албаны даргын 13 удаагийн тушаалаар аймгийн ГХУС зардлаас нийт **144,541.5** мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авсан байна. Үүнд:
 - А/08 дугаар тушаалын дагуу замын тэмдэг шинээр хийж байршуулахад зориулан анхааруулах самбар хийх зардалд 5,250.0 мянган төгрөг,
 - А/11 дүгээр тушаалын дагуу замын тэмдэг шинээр хийж байршуулахад зориулан анхааруулах самбар хийх зардалд 3,950.0 мянган төгрөг
 - А/16 дугаар тушаалын дагуу гэмт хэрэг зөрчлийн судалгаа, шинжилгээ хийхэд зориулан 3D газрын зураг худалдан авах зардалд 1,656.0 мянган төгрөг,
 - А/21 дүгээр тушаалын дагуу Цагдаагийн албан хаагчдын албаны шуурхай бэлэн байдлыг хангах зорилгоор гар станц авах зардалд 6,700.0 мянган төгрөг,
 - А/23 дугаар тушаалын дагуу сэтгэл ханамжийн судалгаа авах зардалд 4,000.0 мянган төгрөг,
 - А/26 дугаар тушаалын дагуу хөдөлгөөнт эргүүл, хяналт шалгалтын болон нөлөөллийн ажил зохион байгуулах зардалд 1,365.0 мянган төгрөг,
 - А/27 дугаар тушаалын дагуу энгэрийн камер авах зардалд 13,722.5 мянган төгрөг,
 - А/28 дугаар тушаалын дагуу хөдөлгөөнд эргүүл, хяналт шалгалтын ажлыг эрчимжүүлэх зорилгоор мотоцикл авах зардалд 15,500.0 мянган төгрөг,
 - А/29 дугаар тушаалын дагуу олон нийтийн цагдаагийн таних тэмдэг болон тусгай хувцасны зардалд 13,884.0 мянган төгрөг,
 - А/34 дугаар тушаалын дагуу хурууны хээ уншигч төхөөрөмж худалдан авах зардалд 2,850.0 мянган төгрөг,
 - А/40 дүгээр тушаалын дагуу иргэн, хуулийн этгээдүүдийн камерыг камерын нэгдсэн сүлжээнд холбох зардалд 14,650.0 мянган төгрөг
 - А/43 дугаар тушаалын дагуу Цагдаагийн газарт шаардлагатай техник, тоног төхөөрөмж худалдан авах зардалд 41,250.0 мянган төгрөг,
 - А/51 дүгээр тушаалын дагуу гэрлэн гарц шинээр байгуулах зардалд 16,964.0 мянган төгрөг,
 - А/56 дугаар тушаалын дагуу теле камерын “FDF” холболтын төхөөрөмж худалдан авах зардалд 2,800.0 мянган төгрөг.
- Аймгийн Засаг даргын 7 удаагийн захирамжаар ЗДНХ, болон мөрийн хөтөлбөрийн зардлаас нийт **79,655.5** мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авсан байна. Үүнд:
 - А/179 дугаар захирамжаар Бугант тосгоны “Толгойтын даваа гэх газарт түр хяналтын цэг худалдан авах зардалд 19,000.0 мянган төгрөг,

- А/263 дугаар захирамжаар Бугант тосгоны “Толгойтын даваа гэх газрын түр хяналтын цэгт үүрэг гүйцэтгэж байгаад эвдэрсэн тээврийн хэрэгслийн шатахуун, засварын зардалд 9,332.0 мянган төгрөг,
- А/272 тугаар тушаалаар наадмын хамгаалалтын зардалд 5,280.0 мянган төгрөг,
- А/470 дугаар захирамжаар “Теле камерын хяналтын төв”-ын засварын зардалд 10,412.5 мянган төгрөг,
- А/495 дугаар захирамжаар сургалт зохион байгуулах зардалд 2,700.0 мянган төгрөг,
- МН/01 дугаар захирамжаар хорт ургамал устгах зардалд 25,000.0 мянган төгрөг
- А/621 дугаар захирамжаар 4 эгнээ автозамын ажлаар өөрийн эзэмшлийн хашааг татан буулгах, барих зардалд 7,931.0 мянган төгрөг.
- Үндсэн үйл ажиллагааны хүрээнд галт зэвсгийн сургалт зохион байгуулсан сургалтын төлбөрийн орлого **11,490.2** мянган төгрөг.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд дараах худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХАТ хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулж, зохион байгуулсан байна. Үүнд:

				/мянган төгрөгөөр/
№	Тухайн жилд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо, хэмжээ, хүчин чадал	Батлагдсан төсөв	Гэрээний дүн	Худалдан авах ажиллагаанд мөрдөх журам / Тендер шалгаруулалтын арга
1	Шатахуун, шатах тослох материал	168,619.2	168,515.7	НТШ
2	Тоног төхөөрөмж	41,250.0	41,165.9	Харьцуулалтын арга
	Нийт дүн	209,869.2	209,681.6	

Шатахуун, шатах тослох материал нийлүүлэх тендерийг 3 удаа зарлаж НИК ХХК, тоног төхөөрөмж нийлүүлэх тендерт Монтех дистрибьюшн ХХК тус тус шалгарч, гэрээ байгуулан худалдан авах ажиллагааг гүйцэтгэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Цагдаагийн газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн зардлын данс, цалингийн бүртгэлтэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор О.Анхбаяр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сэлэнгэ аймгийн Цагдаагийн газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 46/268 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 4,553,685.2 мянган төгрөгөөс 1 хувиар буюу **45,536.9** мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж дүгнэсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

“Төрийн хэмнэлтийн тухай хууль”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Сэлэнгэ аймгийн Цагдаагийн газар нь дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- *Цалин хөлснөөс гадуур ажлын хөлс, урамшуулал олгоогүй,*
- *Үндсэн үйл ажиллагаа нь шуурхай албаны болон бэлэн байдлыг хангах чиг үүрэгтэй этгээдийн албаны гар утасны зардлаас бусад гар утасны зардал гаргаагүй,*
- *Баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, байгууллагын ой зэргийг зохион байгуулахад төсвөөс зарлага гаргаагүй.*
- *Зочин, төлөөлөгч хүлээн авах, үдэх, бэлэг дурсгалын зүйлсэд зардал гаргаагүй,*
- *Албан хэрэг хөтлөлтийн e-doc систем ашиглаж бичиг хэргийн зардлыг бууруулсан.*

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор

www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Сэлэнгэ аймгийн Цагдаагийн газар нь мэдээлбэл зохих 28 төрлийн 183 мэдээллээс 182 мэдээллийг хугацаанд нь, 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Үүнд:

Хугацаа хоцроосон:

- Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт- эдийн засгийн ангиллыг 1 удаа,

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Дарга, тэргүүлэх аудиторын 2024 оны 12 дугаар сарын 02-ны 173 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг нотлох баримттай тулган баталгаажуулахад 100.0 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	2	18,100.0	2	18,100.0	100.0
Зөвлөмж	1	0.0	1	0.0	100.0
Нийт дүн	3	18,100.0	3	18,100.0	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сэлэнгэ аймгийн Цагдаагийн төсвийн шууд захирагчийн бус дээд шатны төсвийн захирагчийн шийдвэрээр хэрэгжсэн дараах асуудлыг дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

1.ЦЕГ-ын даргын 2024 оны 16/1368 дугаар албан бичгийн хариу болох Татварын Ерөнхий газрын 2024 оны 06/1169 дугаар албан бичгийн дагуу “Цагдаагийн албан хаагчид олгох мөнгөн урамшил”-ын зардлаас **5,046.5** мянган төгрөгийн ХХОАТ суутгасан байна.

2.ЦЕГ-ын даргын 2024 оны Б/1680 дугаар тушаалын дагуу “Төвийн бүсийн удирдах ажилтны зөвлөгөөн”-д оролцсон ЦЕГ, Мандал сумын Цагдаагийн хэлтэс, Төв

аймгийн Цагдаагийн газар, Дархан Уул аймгийн Цагдаагийн газар, Сайхан сумын Цагдаагийн хэлтэс зэрэг байгууллагуудын нийт 39 албан хаагчийн хоол, байрны зардлын **5,890.0** мянган төгрөгийг тус газрын албан томилолтын зардлаас зарцуулсан байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “*Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*” гэж заасныг зөрчсөн байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар **16,416.7** мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс 308.2 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 1,234.0 мянган төгрөгийн албан шаардлага, 14,876.5 мянган төгрөгийн 1 зөвлөмж хүргүүлсэн.

5.1 Төлбөрийн акт

1. Газрын даргын 2024 оны Б/111 дугаар тушаалаар сануулах сахилгын шийтгэл ногдуулсан зохицуулагч Л.Лхагвасүрэнгийн сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа нь дуусаагүй байхад **308.2** мянган төгрөгийн улирлын ажлын үр дүнгийн урамшуулал олгосон нь Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.6 дахь “*Төрийн жинхэнэ албан хаагч сахилгын шийтгэл ногдуулсан өдрөөс хойш 1 жилийн дотор сахилгын шийтгэл хүлээгээгүй бол түүнийг сахилгын шийтгэлгүйд тооцно*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “*Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэлт: Илүү олгосон цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

5.2 Албан шаардлага

1.Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлаас бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд **1,234.0** мянган төгрөгийг гүйлгэн зарцуулж, бодитоор тайлагнаагүй нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “*Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*” гэж заасныг болон Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “*Зардлын эдийн засгийн ангилал ашиглах зааврын*”-ыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэлт: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж байх албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

1.1 Илрүүлэлт: Ахмадын санг тайлант жилийн төсөвт тусган батлуулалгүйгээр цалингийн хэмнэлт 4,027.5 мянган төгрөг, НДШ-ийн зардлын хэмнэлт 2,748.9 мянган төгрөг, бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлын хэмнэлт 6,600.0 мянган төгрөг, тэтгэмж, урамшууллын зардлын хэмнэлт 1,500.0 мянган төгрөг зэрэг нийт **14,876.5** мянган төгрөгийг төрийн сан дахь тус сангийн 100130012503 тоот дансанд шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Ахмадын сан байгуулан ажиллуулах журам”-ын 1.3 дахь “Төсөвт байгууллагын тухайд цалингийн сангийн 3 хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр сан байгуулж, шаардагдах хөрөнгийг төсөвтөө жил бүр тусгана” гэсэн заалттай нийцэхгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Иймд ахмадын санд төвлөрүүлэх хөрөнгийг тухайн жилийн төсөвт тусгуулж батлуулсны үндсэн дээр санхүүжүүлэх нь зүйтэй байна.

2. Цалингийн бүртгэлтэй холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт: Улирал бүр ажлын үр дүнгээр цалин бууруулах тушаал гарган давхардсан тоогоор 114 албан хаагчийн цалин хөлсийг **5-20 хувиар** бууруулахдаа цалингийн цэсийн нэмэгдэл талд хасах утгаар оруулж цалингийн тооцоолсон өглөгийг бууруулан, цалингийн зардлыг нэмэгдүүлэн бүртгэсэн байна.

Энэ нь Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар батлагдсан “Төсөвт байгууллагад мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын ажиллагчидтай холбогдсон зардлын бүртгэлийн 3.5 дахь “Ажилтны цалин хөлс, олговрыг дараах байдлаар бүртгэнэ, 3.5.(в) дэх “цалингийн урьдчилгаа, суутгасан суутгалууд болон гарт олгох цалингийн дүнгээр: Дт.Цалингийн тооцоо Кт.Цалингийн өглөг” гэсэн заалттай нийцээгүй тул цалингийн тооцооллыг зөв хийж, бүртгэлийг стандартын дагуу гүйцэтгэх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5² дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

² Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл



Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн	
							Тоо	Дүн	Тоо	Дүн			

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Цалин илүү олгосон	1	308.2	1	308.2									
Зардлын бүлэг хооронд гүйлгэн зориулалт бусаар зарцуулсан	1	1,234.0			1	1,234.0							
Зардлын хэмнэлтийг ахмадын сангийн дансанд шилжүүлсэн	1	14,876.5					1	14,876.5					
Цалинг буруу бүртгэсэн	1						1						
Дүн	4	16,418.7	1	308.2	1	1,234.0	2	14,876.5					

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Нийт дүн								